



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.05 № 623
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021293

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын мөрийн хөтөлбөр (...16...хуудас)-ийг хавсаргав


Хувийг: Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Сайн Ардчилсан иргэдийн нэгдсэн намын Бага хурлын
2024 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн 24/03 тоот
Тогтоолын хавсралт



**САЙН АРДЧИЛСАН ИРГЭДИЙН НЭГДСЭН НАМЫН
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН
САЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

“САЙН СОНГОЛТ”

УЛААНБААТАР ХОТ

Агуулга:

1. САЙН УЛС ТӨРИЙН БОДЛОГО	4
2. САЙН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО	4-5
3. САЙН НИЙГМИЙН БОДЛОГО	5-6
4. САЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО	6-7
5. САЙН БОЛОВСРОЛ, СОЁЛЫН БОДЛОГО	7-8
6. САЙН ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГО	8-9
7. САЙН ГАДААД БОДЛОГО	9-10
8. САЙН БАТЛАН ХАМГААЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ БОДЛОГО	10-11
9. САЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	11-12
10. САЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО	12-13
11. САЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО	13-15
12. САЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО	15-17
13. САЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	17-18
14. САЙН ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, БАЯЛГИЙН САНГИЙН БОДЛОГО	18-19
.....	18-19
15. САЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	19

Зорилго.

Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн нам (САИН) нь хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг чиг хандлагыг эрхэмлэн Ардчилсан Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хамгаалж, Монгол улсын ирээдүйн төлөө хувь хүний хөгжил хүмүүжил, мэдлэг боловсролыг дээдэлсэн, чадварлаг гишүүдээр намаа бүрдүүлэн дэвшилтэт бодлогуудыг хэрэгжүүлж, ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлсэн, улс төрийн болон эдийн засгийн хувьд дэлхийн жишигт хүрсэн тогтвортой бодлого хэрэгжүүлэх, улсын аюулгүй байдлыг бүрэн хангаж, авлига, хээл хахуульгүй, хувийн эрх ашгаас ангид нийгэм бий болгох зорилго тавин ажиллаж байна.

“САИН” Нам нь Монголын ард түмний итгэлийг хүлээж олонхи болсон тохиолдолд Хүнд үйлдвэрлэлүүд хөгжсөн, Байгаль орчныг хамгаалах, Байгалийн баялгийг зохистой ашиглаж, нөхөн сэргээх хууль эрх зүйн орчныг сайжруулж, Баялгийн санд хуримтлагдсан хөрөнгийг тэгш хуваарилах, иргэд, үндэсний үйлдвэрлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг зээлийн хүүгийн дарамтгүй, уян хатан татварын тогтолцоотой эдийн засаг, санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх, нийгэмд шударга ёсыг хэвшүүлэхэд онцгойлон анхаарч “ШУДАРГА БОЛ ЭВТЭЙ, ЭВТЭЙ БОЛ ХҮЧТЭЙ” гэсэн эртний сургаалыг баримтлан улс эх орондоо “САЙН ТӨР”-ийг цогцлооход бүхий л нөөц боломжоо дайчлан ажиллах болно.

6317144798
ГТ0А0048 3190269

НЭГ: “САИН” УЛС ТӨРИЙН БОДЛОГО.

Эв нэгдэл, эх оронч үзлийг эрхэмлэн дээдэлж, шууд Ардчиллын шударга зарчмаар байгуулагдсан, хуулийг сахиулан биелүүлдэг, төрийн залгамж чанарыг хадгалсан, хариуцлага, хяналтын тогтолцоог мөрдлөг болгон, өндөр ёс зүйтэй, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлдэг, улс төрийн болон төрийн албан хаагчдаараа дамжуулан чиг үүргээ чандлан биелүүлдэг засаглалын бүтцийг хэрэгжүүлнэ.

- 1.1 Үндсэн хуулиа хэлбэрэлтгүй сахин үзэл санааг нь ягштал баримталдаг байна.
- 1.2 Шударга сонгуулиар байгуулагдсан, хуулийг сахин биелүүлэгч байна.
- 1.3 Үндэсний эрх ашгийг сахин хамгаалж иргэд сонгогчдод ил тод, нээлттэй байна.
- 1.4 Эрх үүргийн тэнцвэр, хариуцлагын тогтолцоог хангана.
- 1.5 Явцуу ашиг сонирхлоос ангид байж хүн ардаа гэсэн төрийн үйлчилгээг бий болгож хэрэгжүүлнэ.
- 1.6 Эрх мэдэл, эд хөрөнгийн шуналгүй, өндөр ёс суртахуунтай төрийн албан хаагчдыг бэлтгэнэ.
- 1.7 Эвсэлд үл нэгдэх төвийг сахисан энх тайванч гадаад бодлоготой байна.
- 1.8 Байгальд ээлтэй нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг чиг болгосон технологи, мэдээллийн салбарт Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Олон Улсын гэрээ, конвенцид нийцсэн даяарчлалыг зөвшөөрч, төрт ёсны уламжлалаа дээдлэн улс төр, нийгэм, соёл, үндэсний баялгийн хүрээнд дангаарчлалыг эрхэмлэнэ.
- 1.9 Шинжлэх ухааны ололт, нарийн мэргэжлийн судалгаа, үндэсний эрдэмтэн мэргэдийн зөвлөмж, бүх нийтийн хэлэлцүүлэг, оролцооны ардчилал зэрэг олон талт хүчин зүйлийг мөрдлөг болгож бодлого, үйл ажиллагаагаа тогтмол чамбайруулан цэвэршүүлнэ.
- 1.10 “САИН” төр"-ийг цогцлоохдоо үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүн ардынхаа эрх зорилгод түшиглэн Монгол улсаа хөгжлийн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд засаг захиргааны нэгжийг чадварлаг, цомхон болгоно.
- 1.11 “САИН” төр"-ийн Засгийн бүтэц нь цэгцтэй цомхон, чиг үүргийн хувьд давхцалгүй, хүнд сурталгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, шударга ёс, эв нэгдлийг эрхэмлэн хүн ардаа үзүүлэх үйлчилгээ нь хөнгөн шуурхай байна.
- 1.12 “САИН” төр нь “САИН НИЙГЭМ”, “САИН ЭДИЙН ЗАСАГ”, “САИН БАЙГАЛЬ ОРЧИН” гэсэн гурван үндсэн бодлогод тулгуурлах бөгөөд эдгээр гурван баганыг бат бөх, тогтвортой байлгахыг эрхэмлэнэ.

ХОЁР: “САИН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО”

Хуулийг чандлан сахиулагч, шударга ёсыг эрхэмлэн хангагч, авлигаас ангид, шудрага шүүх, прокурорын тогтолцоог “САИН Хууль зүйн” бодлогоор дамжуулан амьдралд хэрэгжүүлнэ.

- 2.1 Иргэний үндсэн эрхийн баталгааг хангах Шүүх, прокурорын байгууллагын тогтолцоог олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх бодлого баримтлана.

- 2.2 Ардчилсан, ил тод, хариуцлагатай засаглалын төлөө тэмцдэг жирийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг тууштай дэмжинэ.
- 2.3 “Хүний эрхийн түгээмэл тунхаг”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын факт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, “Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенциуд зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын аргачлалыг дэмжинэ.
- 2.4 Хүний эрхийг хөсөрдүүлэгч аливаа дарангуйлагч дэглэмүүдийг эсэргүүцнэ.
- 2.5 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гэр бүл,жендер, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дах бэлгийн дарамт, сэтгэл санааны хүчирхийлэлтэй тэмцэх зорилгоор хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулна.
- 2.6 Хувь хүний халдашгүй дархан байдалд ямар ч хэлбэрээр хүч хэрэглэхийг эсэргүүцнэ.
- 2.7 Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, Хар тамхи, хүн худалдаалах болон мөнгө угаах, цахим орчинд үйлдэгдэх аливаа гэмт хэрэг зэрэг улс дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх албыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлж чиг үүргийг зааглан гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.8 Тусгай хэрэгцээт, зорилтот бүлгийн иргэдийн сонгох, сонгогдох тэгш эрх, мөн улс төр, нийгэм, эдийн засгийн аль ч салбарт бусдын адил ажиллах, аюулгүй амьдрах орчин нөхцөл боломжийг нэмэгдүүлэх тусгай бодлого боловсруулан ажиллана.
- 2.9 Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх, сэтгүүлчийн идэвхтэй үйл ажиллагааг дэмжих, мэдээ мэдээллийн нээлттэй, цогц эх сурвалжийг хамгаалах, бодитой орших боломж нөхцөлийг бүрдүүлж дэмжинэ.
- 2.10 Орон сууц захиалсан иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах, орон сууц захиалсан тохиолдолд урьдчилсан бүртгэлийг төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрт бүртгэдэг байх, хариуцлага, хяналт шалгалтыг чангатгах замаар иргэдийн эрх ашгийг хамгаалах бодлого баримтална.
- 2.11 Газрын тухай хуульд заасны дагуу иргэн бүр хуульд заасан хэмжээгээр нэг удаа газар өмчлөх эрхийг эдлүүлж, иргэн бүрт олгох “ГАЗАР” үндэсний хөтөлбөрийг санаачлан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ГУРАВ: “САЙН НИЙГМИЙН БОДЛОГО”

Хүний эрхийг дээдлэн хуулийг сахин биелүүлдэг, шударга ёсыг тогтоохын төлөө тууштай тэмцдэг, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг төр нь зонхилон хариуцдаг, “хил, хэл, хүн”-ээ гэсэн үзэл баримтлалыг эрхэмлэн хөдөлмөрийн насны бүх иргэд, ахмад настан, тусгай хэрэгцээт, зорилтот бүлгийн иргэд, хүүхэд, нийгмийн бусад бүлгүүдэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлэх зарчмыг баримтлана.

- 3.1 Нийгэм эдийн засгийн бодлоготой холбогдсон төрийн байгууллагуудын бүх шатны шийдвэр нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэн бүрт тэгш эрхтэй байх зарчмыг баримтална.
- 3.2 Ажилгүйдлийг бууруулах зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн санал санаачилгыг төрөөс бүх талаар дэмжиж, шаардлагагүй тохиолдолд тусгай

- зөвшөөрөл шаардахгүй байх, норм, стандарт, дүрэм журмыг шинэчлэн сайжруулна.
- 3.3 Төвлөрсөн суурин газрууд болох аймаг, нийслэлийн агаар, хөрсний бохирдлыг бууруулах, авто замын түгжрэлийн эсрэг дорвитой ажил эхлүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тууштай дэмжинэ.
- 3.4 Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэн бүрт хүрч ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

ДӨРӨВ: "САЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО"

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хүрээнд "Эрүүл мэнд"-ийн бодлогыг амьдралд хэрэгжүүлнэ.

- 4.1 Үйл ажиллагаагаа хэвийн явуулж буй нийслэл, аймгийн лавлагаа шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, шинжилгээний чадамжийг дээшлүүлэх, боловсронгуй болгох бодлого баримтлана.
- 4.2 Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг нэгтгэж дотоодын хэмжээнд нэг үндсэн баазаас мэдээлэл авдаг, солилцдог, эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд бүгд одоо ашиглагдаж байгаа аль нэг программыг ашиглах тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлана.
- 4.3 Яаралтай тусламжийн үндэсний чадавхыг дээшлүүлэх, Нийслэл, Орон нутгийн түргэн тусламжийн үйлчилгээ иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- 4.4 Эмч, сувилагч, эмнэлгийн ажилтныг нийгмийн асуудлын баталгааг хангахад чиглэсэн аливаа санал, санаачлагыг дэмжиж хэрэгжүүлэх бодлого баримтлана.
- 4.5 "Идэвхтэй эрүүл амьдрал" хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, стресс бухимдлаас ангид байх эрүүл амьдралын дадал хэвшлийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх. Нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрүүдийг боловсронгуй болгох, эрүүл хооллолт, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний хэрэглээг хязгаарлаж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах санал санаачилгыг дэмжинэ.
- 4.6 ЭМД-н сангаас улсын эмнэлгүүдийг санхүүжүүлдэг тогтолцоог хэвээр хадгалж, хувийн эмнэлгүүд иргэдэд ЭМД-аар үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд, нэмэлт төлбөр авахгүй байх, ЭМД-г зүй зохистойгоор зарцуулах чиглэл баримтлана.
- 4.7 Өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудын мэргэжлийн эмнэлгийн байгууллагуудтай хамтран ажиллах аливаа санал санаачилгыг дэмжинэ.
- 4.8 Эмнэлгийн ажилтанд ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж өвчтөнд үйлчлэх, асаргаа сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. Анагаахын боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэжлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох төр хувийн хэвшлийн түншлэлийг тууштай дэмжинэ.
- 4.9 Эм, био бэлдмэлийн худалдаанд хатуу хяналт тогтоож иргэд болон мал амьтны эрүүл мэндэд анхаарна.
- 4.10 Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах, тэднийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд нийтийн биеийн тамирыг амьдралд хэвшүүлж бүх нийтээр эрүүл, аюулгүй орчинд аж төрөх нөхцөлийг үе шаттай бүрдүүлнэ.
- 4.11 Архи, тамхи зэрэг хорт зуршил, төрөл бүрийн мансууруулах бодисын аюулаас ард иргэд, хойч ирээдүйгээ хамгаалах архидалт, мансуурлын эсрэг хөтөлбөр, сургалтын санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 4.12 Иргэдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн суурь боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсронгуй болгоно.

- 4.13 Бүх төрлийн хорт хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлох, хиймэл оюун ухаан, инноваци технологийг бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийг хорт хавдар өвчнийг эрт оношлох, эмчлэх боломжоор хангаж, клиникийн тусгай эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйлчилгээг хөгжингүй орнуудын түвшинд хүргэхийн төлөө тууштай ажиллана.
- 4.14 Монголын уламжлалт анагаах ухааныг дэлхийд өрсөлдөхүйц брэнд болгож экологид суурилсан эрүүл мэндийн бодлого баримтлана.
- 4.15 Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг оновчтой шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлнэ.
- 4.16 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн тогтолцоог хэрэгжүүлэх бодлого баримтлана.

ТАВ: "САЙН БОЛОВСРОЛ, СОЁЛЫН БОДЛОГО"

Эх оронч, эрүүл чийрэг хойч үе бэлтгэх, сурч боловсрох "гарааны ижил нөхцөл"-өөр хангаж "чанартай боловсрол" олгох, уламжлалт соёлоо дээдэлдэг, соёл урлагийг хөгжүүлэх, "инноваци"-ийг "Боловсрол, Соёл"-ийн бодлогоор дамжуулан амьдралд хэрэгжүүлнэ.

- 5.1 Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2 заалтыг үндэслэн өсвөр үеийн боловсрол эзэмших "гарааны ижил нөхцөл"-өөр хангах хууль эрх зүйн орчныг хэрэгжүүлнэ.
- 5.2 "Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний хөтөлбөр"-ийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.3 Боловсролын салбарын бүх байгууллагуудад бэлгийн дарамт, жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүчирхийлэл гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авдаг журамтай болгох талаар тууштай ажиллана.
- 5.4 Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр бүсчилсэн хэлбэрээр ажилладаг ТББ-уудтай гэрээлэн ажиллах төсөлт хөтөлбөрүүдийг дэмжиж, хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлнэ.
- 5.5 Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр төлөвлөгөөг боловсронгуй болгож улс орон даяар нэгдсэн нэг хөтөлбөртэй болгох, цэцэрлэгийн багш ажилчдын нэр хүндийг хамгаалах, нийгмийн баталгааг олон улсын жишигт хүргэх арга аргачлалыг боловсронгуй болгоно.
- 5.6 Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг олон улсын жишигт нийцсэн орчин үеийн техник, тоног төхөөрөмж, материаллаг бааз, багшлах боловсон хүчнээр бүрэн хангах замаар эрэлт ихтэй мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх хөтөлбөрүүдийг тууштай дэмжинэ.
- 5.7 Үндэсний тэргүүлэх мэргэжилтнийг төрийн бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлж уул уурхай, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи, инженерчлэлийн чиглэлээр хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудад сургах сургалтын зардлыг суралцагчийн дүнгийн голчийг үндэслэн төрөөс бүрэн санхүүжүүлдэг тогтолцоог тэгш хүртээмжтэй үргэлжлүүлэх, ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.8 Монгол үндэстний өв уламжлал, зан заншил, байгаль орчинтойгоо зохицон амьдрах чадварыг олон улсын туршлагатай хослуулан шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурласан тогтвортой хөгжил, байгаль орчин, экологийн боловсролыг бүх нийтэд үе шаттайгаар эзэмшүүлэх бодлого баримтлана.

- 5.9 Монголчуудын түүхэн уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүйн нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжинэ.
- 5.10 Сонгодог урлагийн бүх төрлийг жигд хөгжүүлэх авьяас билигтнүүдээ дэмжинэ.
- 5.11 Үндэсний өв уламжлал, түүх соёл, болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн аливаа хөтөлбөрүүдийг дэмжиж, олон улсад сурталчилан таниулах үйл ажиллагааг тууштай дэмжинэ.
- 5.12 Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дорвитой ахиц гаргана.
- 5.13 Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөнө.
- 5.14 Гадаад орны дэвшилтэт сургалтын тогтолцоог нутагшуулах ажлыг хэрэгжүүлэхдээ багшлах боловсон хүчнийг харилцан солилцох, урилгаар ажиллуулах бодлого баримтлана.

ЗУРГАА: "САЙН ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГ"

"ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГ"-оор дамжуулан Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарыг мэдлэгт суурилсан тэргүүлэх салбар болгон инновацын тогтолцоог үндэсний хэмжээнд дэлгэрүүлэх бодлого баримтлана.

- 6.1 Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, суурь технологийг тодорхойлон хэрэгжүүлж, судалгаа, боловсруулалтын ажлын сонголтыг сайжруулан үр өгөөжийг дээшлүүлнэ.
- 6.2 Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлага, үйл ажиллагааны санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний ажилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг тасралтгүй нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ.
- 6.3 Үндэсний хэмжээний томоохон инновацын төслийг Монгол Улсыг хөгжүүлэх сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сангийн хамтарсан санхүүжилтээр бүрэн мөчлөгөөр нь тасралтгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвшүүлнэ.
- 6.4 Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацын соёлыг нэвтрүүлэх, төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.5 "Залуу судлаачдыг дэмжих" зорилтот хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн болон санхүүжилтийн бодлого боловсруулж хэрэгжилтэд шинэчлэл хийнэ.
- 6.6 Төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг олон улсад сурталчлан таниулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг дэмжин урамшуулах, суурь судалгааны шилдэг бүтээлүүдийг нийтийн хүртээл болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

ДОЛОО: "САЙН ГАДААД БОДЛОГО"

Дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эвсэлд үл нэгдэн төвийг сахих, хөрш орнуудыг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл гэж үзэн гурван тулгуурт бодлого

зэрэг найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг "Гадаад бодлого"-оороо дамжуулан хэрэгжүүлнэ.

- 7.1 Байгаль орчныг сүйтгэж, Хүн төрөлхтнийг үй олноор хөнөөх зэвсгийг иж бүрнээр нь эцэслэн хориглох явдлыг баталгаажуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг тусгасан бүх нийтээр бүрэн зэвсэг хураах олон улсын санал санаачилгыг дэмжинэ.
- 7.2 Гадаадад байгаа Монгол улсын иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, иргэдийг эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжих, гадаадад гэрээгээр ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулах, Монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 7.3 Улс орныхоо аюулгүй байдлыг зэвсэгт хүчин дээр голлон тулгуурлах бус, улс төр, эдийн засаг, нийгмийн эрүүл хөгжил, байгаль орчны аюулгүй байдал, хүний эрхийг хүндлэн дээдлэх, даян дэлхийн улс гүрнүүдтэй энх тайвнаар зэрэгцэн орших зэрэг тулгуур зарчмуудад үндэслэн хамгаална.
- 7.4 Зэвсэгт хүчний харьцааг тэнцвэржүүлэхийг чухалчилдаг бус нийгэм, эдийн засаг, экологи, сэтгэлзүй, соёлын асуудлыг урьтал болгодог даян дэлхийн аюулгүй байдлын цогц үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.
- 7.5 Хөрш орнуудтайгаа эрх тэгш зарчмыг баримтлан хамтран ажиллаж Монгол улс, ОХУ, БНХАУ хоорондын хил хязгаарын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч хилийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулах бодлогыг баримтална.
- 7.6 Бүс нутгуудын хүрээнд эдийн засгийн жигд хөгжлийн үзэл баримтлалыг бүрдүүлж хөрш орнуудтайгаа хамтран хөгжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 7.7 Хөрш улсуудын эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт өргөн хүрээг хамарсан хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлогыг эрхэмлэнэ.

НАЙМ: "САЙН БАТЛАН ХАМГААЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ БОДЛОГО"

Улсын хил, дотоодын аюулгүй байдлыг хамгаалах цомхон, чадварлаг мэргэжлийн армитай байх, залуу хүн бүр эх орныхоо хил хязгаартай бүрэн танилцах, түүнийг хамгаалах үйл хэрэгт биечлэн оролцож "Ургах нарнаас шингэх наран зүг" уриан дор цэргийн алба хаах зэрэг асуудлыг "Батлан хамгаалах, Хил хамгаалах" бодлогоор дамжуулан амьдралд хэрэгжүүлнэ.

- 8.1 Монгол улс түүхт уламжлалдаа үнэнч байж улс эх орноо батлан хамгаалах үзэл баримтлалыг эрхэмлэнэ.
- 8.2 Барилгын цэргийн ангийн бүрэлдэхүүнийг Монгол улсын бүтээн байгуулалтад оролцуулах бодлогыг дэмжинэ.
- 8.3 Цэргийн насны иргэдийн мэдлэг, чадварыг үндэслэн харьяалах мэргэжлийн цэргийн ангид хүсэлтийг нь харгалзан үзэж, хуваарилах бодлогыг баримтална.

ЕС: "САЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО"

Олон улсын жишигт нийцсэн банк санхүүгийн тогтолцоо, байгаль экологи, инновацид суурилсан өндөр бүтээмжтэй аж үйлдвэр, эрчимжсэн технологид тулгуурласан хөдөө аж ахуй, олон зуунаар дасан зохицсон уламжлалт мал аж ахуй, нөхөн сэргээгдэх

түүхий эдэд түшиглэн эрчим хүч, цогц сүлжээгээр хангагдсан орчин үеийн зам харилцаа, дэд бүтцээс хараат бус барилгажуулалт, төрийн бодит оролцоогоор дэмжигддэг жижиг, дунд үйлдвэрлэл зэрэг олон талт бодлогуудыг жигд хэрэгжүүлэн экологийн баримжаат эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.

- 9.1 Уламжлалт соёл иргэншил, байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийг нэвтрүүлсэн, хариуцлагатай зах зээлийг бэхжүүлсэн, ногоон эдийн засгийн бодлого барьсан, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон байна гэдэг томъёоллыг төрийн бодлого болгоно.
- 9.2 Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн хариуцлагын тогтолцоог Монгол улсын үндсэн хуульд заасны дагуу Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхын санал авсан асуудлыг шийдвэрлэж төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог чадавхжуулна.
- 9.3 Төсвийн хөрөнгө оруулалтыг богино, дунд, урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ.
- 9.4 Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглахдаа нийт баялгийн тодорхой хувийг "Орон нутгийн баялгын сан"-д төвлөрүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэл баримтална.
- 9.5 Бизнесийн үйл ажиллагааг нэмүү өртөг шингээлтийн түвшин болон байгаль экологид ээлтэй технологид суурилсан байдлыг үндэслэн бодлогоор дэмжинэ.
- 9.6 Экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох зарим үйлдвэрлэлийг оновчтой бодлогоор дэмжинэ.
- 9.7 Аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг төрөөс дэмжих бодлогыг тууштай баримтална.

АРАВ: "САЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО"

Төрөөс экологид ээлтэй нөхөн сэргээгдэх эрчим хүч, дэд бүтцийн чанар хүртээмжийг сайжруулж улс даяар өргөн ашиглах, хөгжлийн хурдасгуур болох зам харилцааны цогц сүлжээг байгуулах, ард иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл, баталгааг хангаж хот суурин газруудын төлөвлөлтийг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах замаар "Дэд бүтцийн" бодлогыг хариуцан хэрэгжүүлнэ.

- 10.1 Түүхий эдийг зонхилон ашиглах бодлогыг хэрэгжүүлж нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийг хариуцлагатай ашиглана.
- 10.2 Хөдөө аж ахуйн малын гаралтай түүхий эд боловсруулах хонины ноосоор барилгын эко дулаалга хийх технологийг дэмжин, Хөнгөн үйлдвэрийн цогцолборт давуу ашиглах, Уул уурхайд тулгуурласан Нефть боловсруулах, Ган хайлуулах зэрэг Хүнд үйлдвэр, Аж үйлдвэрийн цогцолбор нь улс орны хөгжлийн гол тулгуур учир үйлдвэржилтийг нягт холбосон зам тээвэр, харилцаа холбоо, үйлчилгээний сүлжээ бүхий дэд бүтцээр холбох хууль эрх зүйн орчныг хэрэгжүүлнэ.
- 10.3 Байгалийн баялаг хязгаарлагдмал гэдгийг хүлээн зөвшөөрч нөөц баялгийг ашиглахдаа өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг хангахын тулд хог, хаягдлыг дахин боловсруулж ашиглах төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.
- 10.4 Эрчим хүчний зөв зарцуулалттай, байгальд ээлтэй технологийг хөгжүүлж, Аж үйлдвэржилт болон улс орны хөгжилд голлох үүрэг гүйцэтгэх эрчим хүчний салбарт (нар, салхи, ус, газрын гүний дулаан, био хий) Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоонд тулгуурлан дэмжинэ.

- 10.5 Эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулж, хоёр хөрш оронтой эрчим хүчний дэд бүтцээр холбогдон, хэрэглээний онцлогтой уялдуулан экспорт, импортын асуудлыг оновчтойгоор шийдвэрлэх гадаад бодлогыг тогтвортой хэрэгжүүлнэ.
- 10.6 Эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийг ашиглах, экологийн эрчим хүчийг үйлдвэрлэх техник, технологийг хөгжүүлэх аливаа санал санаачилга, судалгааг дэмжинэ.
- 10.7 Бүс нутгийн тээвэр зуучлалын үйлчилгээг шинэ түвшинд гаргахыг эрмэлзэнэ.
- 10.8 Аймгийн төвийг сумдын төвүүдтэй холбосон хатуу хучилттай авто замын хөрөнгө оруулалтыг төсвийн болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг эрэлхийлнэ.
- 10.9 Авто замын барилга угсралт, засвар, арчлалтын норм дүрэм, стандартыг боловсронгуй болгож монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологи нэвтрүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг дэмжинэ.
- 10.10 Байгалийн түүх дурсгалт газруудад аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах хувийн хэвшлийн санал санаачилгыг төрийн бодлогоор түншлэлийн хүрээнд дэмжинэ.
- 10.11 Байгаль экологид ээлтэй дэвшилтэт техник, технологид суурилсан дэд бүтцээс ангид барилгажуулалтыг дэмжих бодлогыг төрөөс баримтлана.
- 10.12 Барилгын дулаан хадгалалтад стандарт тогтоож хяналт тавьж ажиллана.
- 10.13 Байгаль экологид сөрөг нөлөөгүй салхины, газрын гүнийн, нарны эрчим хүчний халаалтын системийг төвийн дулааны шугамаас алслагдсан барилга, байгууламж, хувийн орон сууц, амралт сувиллын газар, жуулчны баазад нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 10.14 Нар, салхины эрчим хүчийг ашиглан гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийн асуудлыг эрчим хүчний хэмнэлттэй нарны коллектороор шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 10.15 Барилгын халаалт, хэрэгцээний халуун усны системийг цогцоор нь шийдэх нарны эрчим хүчний өндөр чадалтай цэнэг хураагуур болон бусад жижиг тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, импортоор оруулж ирэхийг дэмжинэ.
- 10.16 Гэр хорооллын барилгажуулалтыг дэмжиж дэд бүтэц, инженерийн шугам, сүлжээг улсаас санхүүжүүлэх, нөөц боломжийг эрэлхийлж, агаар, хөрсний бохирдол, эрүүл ахуй орчинг цогцоор нь шийдвэрлэх бодлогыг баримтална.
- 10.17 Аймаг, сумдуудын орон сууцны болон гэр хорооллын ундны цэвэр усны хоолойг (төв магистрал шугам) зэс хоолойгоор солих бодлого баримтлана.

АРВАН НЭГ: “САЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО”

Орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан Эрчимжсэн газар тариалан, олон зуунаар өвлөгдөн ирсэн нүүдлийн орчинд дасан зохицсон Уламжлалт мал аж ахуйн хөгжих боломжийг төрийн бодлогоор дэмжиж амьдралд хэрэгжүүлнэ.

- 11.1 Газар ашиглалт, хөрсний ялзмагийг сайжруулах, усалгаатай тариаланг хөгжүүлэх, тариалангийн газрыг зориулалтын дагуу ашиглуулах, нано-биотехнологи нэвтрүүлэн, хүний эрүүл мэндийн байдалд зөвшөөрөгдсөн цавуулаг багатай, цавуулаггүй үр тарианы гурил үйлдвэрлэх, зүрх, судас болон бусад өвчнийг илааршихад тустай шинэ таримлыг нутагшуулахад анхаарч, эрчимжүүлсэн газар тариаланг дэмжинэ.
- 11.2 Эрчимжүүлсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг

- төсөл, бодлогоор дэмжинэ.
- 11.3 Усалгаатай газар тариаланд орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж нэгж га талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 11.4 Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд орон нутгаас бодлогоор дэмжинэ.
- 11.5 Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэж, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс дэмжинэ.
- 11.6 Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлж буй аж ахуй нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
- 11.7 Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, орчин үеийн техник, технологитой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангах бодлогыг тууштай баримтална.
- 11.8 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах төсөл хөтөлбөрүүдийг тууштай дэмжиж ажиллана.
- 11.9 Мах бэлтгэлийг чанаржуулахын тулд эмчилгээ, тэжээлийн цэгийг орон нутагт сэргээх бодлого баримтална.
- 11.10 Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох бодлого баримтлана.
- 11.11 Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах аливаа төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 11.12 Ургацын чанарыг сайжруулахын тулд үр тариа, төмс, хүнсний ногоог тариалах, хураах ажлыг хугацаанд нь хийх, тариалах, үрлэх, суулгах, Үр тарианы үйлдвэрлэлийн механикжуулалтыг нэмэгдүүлж, хүнсний ногооны механикжуулалтыг сайжруулах зорилготой аж ахуй нэгжүүдийг төрийн бодлогоор дэмжинэ.
- 11.13 Орчин үеийн дэвшилтэт технологиор Худаг гаргах, хурын ус хуримтлуулах зорилгоор ашиглагдахгүй байгаа бэлчээрийг усжуулж бэлчээрийн ашиглалтыг сайжруулах бодлого баримтална.
- 11.14 Зарим голын усны урсцад тохируулга хийж бороо, цасны усыг хуримтлуулан ган гачигтай үед усжуулах зориулалттай гидротехникийн байгууламжуудыг бий болгох хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжинэ.
- 11.15 Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэхийг эрмэлзэнэ.
- 11.16 Биотехнологи ашиглан малын эм, тариа, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж байгаа аж ахуй нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
- 11.17 Малын гоц халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ.
- 11.18 малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн алилаа санал санаачлагыг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
- 11.19 Хадлан, тэжээл бэлтгэх ажлыг технологийн шинэ шатанд шилжүүлж, өвс, тэжээлийг ил, задгай тээвэрлэх, хадгалах байдлыг бууруулж, өвсний гурил,

- багсармал тэжээлийн үйлдвэрлэлд илүү анхаарч тэжээлийн нэгжтэй тэнцүү өвс, тэжээлийг жил бүр нэмэгдүүлж жилдээ 1 сая тн тэжээлийн нэгжтэй тэнцэх тэжээл бэлтгэж байсан туршлагыг хэрэгжүүлэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийг бодлогоор дэмжинэ.
- 11.20 Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн эрсдэлийг бууруулах бодлого баримтлана.
- 11.21 Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, эрэлт, хэрэгцээ, шаардлагаас үүдэн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэгийг олгох сургалтыг бүхий л талаар дэмжих, тогтмолжуулах, "Малжуулах" төслийг хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлыг орон нутгийн бодлогоор шийдвэрлэдэг бодлого баримтлана.
- 11.22 Малчдад шинэчилсэн техник технологийг ашиглах сургалтуудыг явуулах төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.

АРВАН ХОЁР: "САЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО"

Монгол улс Аж үйлдвэрлэлийн орон болох үндсэн зорилтын хүрээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан Төрийн оролцоот нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

- 12.1 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хүнд, хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубаторыг боловсронгуй болгох, сайжруулах бодлого баримтлана.
- 12.2 Уул уурхайд тулгуурласан Нефть боловсруулах, Ган хайлуулах хүнд үйлдвэр, Хөнгөн үйлдвэр, аж үйлдвэрлэлийн цогцолборуудыг байгуулж хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 12.3 Уул уурхай түшиглэсэн нефть боловсруулах, ган хайлуулах, бага оврын боловсруулах загвар үйлдвэрүүдийг байгуулах, цаашид хөгжүүлэн, хэмжээг ихэсгэх, Аж үйлдвэрийн цогцолбор бий болгон түүхий эдээ дотооддоо боловсруулж, жижиг, дунд үйлдвэрээ түүхий эдээр хангах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжинэ.
- 12.4 Аж үйлдвэрийн цогцолборуудыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг төрөөс бүхий л талаар дэмжинэ.
- 12.5 Жижиг, дунд үйлдвэрийн техникийн шинэчлэлд зориулан бага оврын техник, тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 12.6 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг түргэн шуурхай, шударга, хүртээмжтэй болгоно.
- 12.7 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт зохион байгуулж ажиллуулах бодлого баримтлана.
- 12.8 Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоотой шийдвэр гаргахдаа тэдний ашиг сонирхлыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгаж байна.
- 12.9 Үйлдвэрлэл, үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн аж ахуй нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.

- 12.10 Биотехнологи, нанотехнологи, генийн инженерчлэлийн ололтыг мал эмнэлгийн оношилгооны техник тоног төхөөрөмж болон эм бэлдмэлийг үйлдвэрлэлд ашиглахыг бодлогоор дэмжинэ.
- 12.11 Орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэдэг болон гадаадаас импортолдог аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
- 12.12 Ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөрлөх нөхцөлөөр ханган иргэдийг ядуурлаас гаргах үйлсэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, хувийн хэвшлийг хөгжүүлэхэд төрөөс онцгойлон анхаарч оролцооны дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
- 12.13 Хувийн хэвшлийн хөгжилд үзүүлэх төрийн оролцоо нь тэдэнд тулгарсан бэрхшээлийг арилгах, тэдний нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, бараа бүтээгдэхүүнийг нь худалдан авах, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх явдал байх бөгөөд төрийн зүгээс дэмжинэ.
- 12.14 Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд ээлтэй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого баримтална.
- 12.15 Бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн үйл ажиллагаа орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулна.
- 12.16 Өндөр технологи нутагшуулах төвүүдийг байгуулан ажиллуулж өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж импортоос хэт хараат байдлыг багасгах төсөлт хөтөлбөрүүдийг бодлогоор дэмжинэ.
- 12.17 Хүн амын эрүүл мэнд, байгальд ээлтэй шинэ дэвшилтэт техник, технологид тулгуурлан мал аж ахуйн гаралтай түүхий эд, сүү сүүн бүтээгдэхүүн, "Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах", "Арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх" зэрэг бүс нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөлт хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 12.18 Оёмол, нэхмэл, сүлжмэл, гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг, олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих бодлого баримтална.
- 12.19 Бохир усыг цэвэршүүлэн гаргасан саарал усыг хүнсний хэрэгцээнээс бусад зүйлд дахин ашиглах орчин үеийн техник, технологийг эх орондоо нэвтрүүлж буй аж ахуй нэгжүүдийг төрийн бодлогоор дэмжинэ.
- 12.20 Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах эдийн засаг, эрх зүйн тэгш таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн чөлөөт бүс болон эрх зүйн тусгай зохицуулалттай бүсүүдийг байгуулан ажиллуулж өндөр технологи нутагшуулахыг бодлогоор дэмжинэ.

АРВАН ГУРАВ: "САЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО"

Эртнээс эдүгээг хүртэл уламжлагдан ирсэн уламжлалт эко соёл, амьд байгалиа хайрлан хамгаалдаг, түүний баялгийг шунаг, сувдаг сэтгэлгүйгээр зохистой ашигладаг ардынхаа уламжлалыг хадгалах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах, Монгол орныхоо байгалийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

- 13.1 Экосистемийн нэгдмэл байдал, биологийн төрөл зүйлийг хадгалан хамгаална.
- 13.2 Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж байгалийн жамаар нөхөн үржих, сэргээгдэх орчныг бүрдүүлэх, тэдгээрийг тогтвортой ашиглах бодлого баримтална.
- 13.3 Хүний ёс зүйд үл нийцэх амьтны амь бүрэлгэх “Ангийн аялал жуулчлал”-ыг хуулиар хязгаарлах бодлогыг тууштай баримтална.
- 13.4 Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хэвийн өсөлтийг хангах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж биологийн найдвартай нөөцтэй болохыг чухалчилна.
- 13.5 Олон улс, бүс нутгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ Монгол улсын газар нутгийн шаардлагатай хэсгүүдийг Улсын тусгай хамгаалалтад авах хууль эрх зүйн орчныг сайжруулах бодлогыг баримтална.
- 13.6 Хүрээлэн буй орчинд үзүүлэх хор нөлөө өндөртэй үйлдвэрлэл, үйл ажиллагааг хугацаа болон ашиглалт, стандартын шаардлагаар хязгаарлах бодлого баримтална.
- 13.7 Байгаль орчныг “бохирдуулагч нь төлөгч”, “ашиглагч нь хамгаалагч” байх үзэл санааг хэрэгжүүлнэ.
- 13.8 Говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах аливаа хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, ойн сангийн тодорхой хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах нөхцөл, боломжийг сайжруулах замаар дэмжинэ. ГЮА0048 3190269
- 13.9 Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангах үндэсний хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 13.10 Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах аливаа төсөлт хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 13.11 Ус хуримтлуулах ай савыг ойжуулах ажлыг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 13.12 Улсын хэмжээнд цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах, бохирдлын эрсдэлийг бууруулах төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 13.13 Монгол улсын голын ай сав, экосистемийг сэргээн хамгаалж, тодорхой шаардлагатай газруудад цөөрөм байгуулах замаар ундны усны хангамжид гадаргын усыг ашиглах аливаа төсөл хөтөлбөрүүдийг бодлогоор дэмжинэ.
- 13.14 экосистемийн хямрал буюу агаар, хөрс, усны бохирдлыг зогсоох төсөлт хөтөлбөрүүдийг сайжруулах замаар бодлогоор дэмжинэ.
- 13.15 Ил задгай хог хаях, байгаль орчин бохирдуулах үйлдэлтэй хатуу тэмцэн хуулийн хариуцлага хүлээлгэх тогтолцоог сайжруулна. Мөн байгалиа хамгаалж, хог, хаягдал цэвэрлэдэг “зөв” хандлагыг дэмжинэ.

АРВАН ДӨРӨВ: “САЙН ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, БАЯЛГИЙН САНГИЙН БОДЛОГО.

Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтийг шинэчилж нийтлэг стандартуудыг тогтоох замаар иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж ашигласан болон ашиглаж буй талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгох, аюулгүй ажиллагааны хариуцлагыг чангатган Уул уурхайн хайгуул болон олборлолтын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож Байгаль-Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зарчмыг баримталж,

байгалийн баялгаас орж ирсэн орлогыг улс төрөөс ангид байгалийн баялгийн санд төвлөрүүлж, улам арвижих зарчим дээр тулгуурлан ажиллах бөгөөд сангийн хөрөнгийг улс эх орныхоо нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйлсэд зарцуулах ба “Байгалийн баялгийн сан”-гийн үндсэн хөрөнгө нь халдашгүй дархан байна.

- 14.1 Уул уурхайн лиценз олголтыг шилэн болгож, хууль бус зөвшөөрлүүдийг хүчингүй болгох бодлого баримтална.
- 14.2 Уул уурхайн нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, нөхөн сэргээлтийн зардлыг олборлолт эхлэхээс өмнө төрийн санд төвлөрүүлж, нөхөн сэргээлтэд шаардагдах нэмэгдэл зардлыг тухай бүрд нь гаргуулж, орчны бохирдлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах тухай бодлого баримтлана.
- 14.3 Стратегийн орд газарт нөхөн сэргээлт хийхдээ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, саарал ус ашиглах, газрын гүний усыг ашиглахгүй байх бодлого баримтлана.
- 14.4 Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа үнэт цаас буюу хувьцааг нь Монгол Улсын хөрөнгийн биржээр дамжуулан гадаад зах зээлд гаргах олон улсын стандарт хэм хэмжээг баримтална.
- 14.5 Бичил уурхай эрхлэгчдийг төрөөс бодлогоор дэмжиж хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчныг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгүүлэх бодлого баримтална.
- 14.6 Уул уурхайн салбарт нөхөн сэргээх шаардлага бүхий газруудад үйл ажиллагааг нь санхүүжүүлэх зорилго бүхий хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх үйлсийг дэмжинэ.

АРВАН ТАВ: “САЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”.

Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн гол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан. Тухайн урт хугацааны бодлогын баримт бичгийн наймдугаар бүлэг БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ нь “САИН намын урт хугацааны бодлого, зорилтод нийцэж байгаа тул бидний зүгээс дээрх хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлж, макро бүсүүдийг шинээр тогтоох замаар Дэлхийн улсуудын жишгээр газар нутгаа бүсчлэн хөгжүүлэх зорилт чиглэлийг баримтлан ажиллах болно.

МОНГОЛ УЛС ҮҮРД МАНДАН БАДРАГ !
САЙН АРДЧИЛСАН ИРГЭДИЙН НЭГДСЭН НАМ